



ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

НҮҮРС ОЛБОРЛОЛТ, ГЕОЛОГИ ХАЙГУУЛ


Цанхийн уурхайгаас 2019 онд **16.2** сая тонн нүүрс олборлож, **77.3** сая м³ уулын цулын ажил гүйцэтгэсэн нь 2018 оны энэ үетэй харьцуулахад нүүрс олборлолт **46** хувь, уулын цулын ажил **30** хувиар өссөн үзүүлэлт юм.

Тавантолгойн бүлэг ордод Австрали улсын JORC болон Канад улсын NI 43-101 (National Instrument 43-101) стандартын

дагуу олон улсын нөөцийн тайлан боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

Цанхийн хэсэгт ашиглалтын хайгуулын **15,000** түүш метр, Бортээг, Оорцогийн хэсэгт нарийвчилсан хайгуулын **62,300** түүш метр нийт **77,300** түүш метрийн өрөмдлөг, геофизик, геологийн боловсруулалт судалгааны ажлыг хийж гүйцэтгэжээ.


График: Нүүрс олборлолт (сая тонн)



НҮҮРС БОРЛУУЛАЛТ


“Эрдэнэс-Тавантолгой” ХК 2019 онд **15.5** сая тонн нүүрс борлуулж, **2.66** их наяд төгрөг буюу **1,000.45** сая ам.долларын борлуулалтын орлоготой ажилласнаар өмнөх онтой харьцуулахад борлуулалтын хэмжээ **18%-иар**, борлуулалтын ам.долларын мөнгөн орлого **25%-иар**, борлуулалтын төгрөгийн мөнгөн орлого **34%-иар** өссөн үзүүлэлттэй байна.

График: Борлуулалтын орлого ба борлуулсан нүүрсний хэмжээг графикаар үзүүлэв.




Энэ оны 3-р сард **1.7** сая тонн нүүрс борлуулахаар ачуулсан нь компанийн түүхэнд 1 сард хамгийн их нүүрс ачуулсан үйл явдал болсон юм.

График: Борлуулалтын төлөвлөгөө ба гүйцэтгэлийг сар тус бүрээр харуулав



“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь 2019 оны борлуулалтын хэмжээ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад **18%-иар** өссөн үзүүлэлттэй байна.

График: Цанхийн уурхайн борлуулалтын хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулан харуулав /мянган тонн/



Энэ оны борлуулалтын орлого нь **2.66** их наяд төгрөг буюу, **1,000.45** сая ам.доллар хүрсэн ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад **1.3** дахин өссөн үзүүлэлттэй байна. Мөн 11-р сараас бусад саруудад борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс өссөн байна.

Энэ онд нийт **63** борлуулалтын гэрээ хэрэгжсэнээс **22** гэрээ бүрэн хэрэгжиж дуусжээ. Нийт хэрэгжиж буй гэрээнүүдийг төлбөрийн эерэг баланстайгаар хэрэгжүүлсэн.

Компанийн үйл ажиллагаа эхэлсэн 2011 оноос хойш 2019 оныг өдөр хүртэл нийт хугацаанд **59.1** сая тонн буюу **7.33** их наяд төгрөгийн мөнгөн дүн бүхий нүүрсийг борлуулж, экспортод гаргаад байна.

2019 оны нийт борлуулалтын 64% буюу 9.89 сая тонн (Үүнд коксжих 9.4 сая тонн, исэлдсэн 0.5 сая тонн) нүүрсийг Цанхийн зүүн уурхайгаас, 36% буюу 5.6 сая тонн коксжих нүүрсийг Цанхийн баруун уурхайгаас нийлүүлсэн байна.

Цанхийн уурхайн олборлолтын технологийн явцад гарсан хаягдал, ул таазны хаягдал, балансын бус нимгэн үе давхаргаас гарсан нүүрс, хагарал, тэсэлгээний явцад үүссэн хаягдал зэрэг

балансын бус бохирдолтой нүүрсийг борлуулахаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Нүүрс борлуулалт, экспортын үр ашгийг нэмэгдүүлэх, ЭТТ брэнд бий болгох, уурхайгаас олборлож буй бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын нүүрс баяжуулах үйлдвэрүүдэд нэмүү өртөг шингээн, БНХАУ-ын Хэбэй мужийн зах зээлд хүргэн өрсөлдүүлэх, цаашлаад Цаофэйдянь боомтоор ре-экспорт хийж олон улсын гуравдагч зах зээлд экспортлох зорилтын хүрээнд хамтран ажиллагчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан компанитай түршилтын гэрээг байгуулсан.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг гэрээний үнээр тооцуулах ажлыг зохион байгуулж 2019 оны 1-11 сарын хугацаанд Сангийн яамнаас зарлагдсан “Экспортод гаргасан ашигт малтмалын олон улсын зах зээлийн үнийн мэдээлэл”-д дурдагдсан коксжих нүүрс болон исэлдсэн нүүрсний үнэ нь манай борлуулж буй үнээс өндөр байсан учраас АМНАТ-ыг гэрээний үнээр тооцоолон тайлан мэдээг боловсруулж, хүргүүлсэн.


Исэлдсэн нүүрсний борлуулалтыг нэмэгдүүлэхээр нүүрс

худалдан авагчийн сонгон шалгаруулалт зарласан ба 2019 онд нийт 2020 мянган тонн исэлдсэн нүүрс худалдах, худалдан авах гэрээг шинээр байгуулж, 507.5 мянган тонн нүүрсийг худалдан авагчид нийлүүлсэн байна.

Монгол Улсын Ашигт малтмалтын тухай хуулийн 35.11 дэх заалтыг харгалзан дотоодын аж ахуй нэгжүүдтэй хамтран


ажиллах сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан компаниудтай гэрээ байгуулан ажиллаж, манай компанийн уурхайгаас нийлүүлж буй нүүрсийг нэмүү өртөг шингээн экспортлох боломжийг бүрдүүлэв. Монгол Улсын Оюуны өмчийн газраас “чулуун нүүрс” ангилалд барааны тэмдэгт эзэмшиж эхэллээ.

График: CR China Coking Coal Price Index



Нүүрсний зах зээл 2019 оны 7 дугаар сараас хойш үнэлтэй байсан бөгөөд зорилтот зах зээлийн коксжих нүүрсний дундаж үнийг илэрхийлдэг “CR China Coking Coal Price Index”-тэй дээрх графикаас танилцана уу.

График: Баруун Цанхийн борлуулалтын үнэ /ам.доллар/




Цанхийн Баруун уурхайн нүүрсний үнийг оны эхэн үеийн үнэ буюу 71.25 ам.доллараас шат дараатай, тодорхой хэмжээгээр өсгөж, нүүрсийг тонн тутмыг нь 71.25-71.75 ам.долларын хооронд борлуулж байсан боловч 4-р улиралд олон улсын зах зээлд болон БНХАУ-ын хамаарал бүхий боомтуудад нүүрсний үнэ огцом унаснаас шалтгаалж 64.07 ам.доллараар үнийг тогтоосон.

График: Чалко компанийн үнэ /ам.доллар/




Цанхийн Зүүн уурхайгаас БНХАУ-ын төрийн өмчит Чалко Трейдинг Хонконг компанид нийлүүлж буй нүүрсний үнийг индекс тооцох аргачлалын дагуу улирал тутам тооцоолон гаргаж, 58.2-63.32 ам.долларын хооронд нийлүүлж ажиллалаа.

График: БНХАУ-ын коксжих нүүрсний импортод Монгол улсын эзлэх хувь /сая тн/



Зорилтот зах зээл болох БНХАУ-ын коксжих нүүрсний импортын хэмжээ өмнөх оны мөн үеэс **9.6 сая** тонноор нэмэгдэж **74.7 сая** тонн болсон. Монгол улс **33.8 сая** тн коксжих нүүрс экспортлосон нь тус улсын коксжих нүүрсний нийт импортын 45 хувийг дангаараа бүрдүүлж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад **6.9 сая** тонноор өссөн үзүүлэлт юм.

График: Монгол улсын нүүрсний экспортод "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн эзлэх хувь /сая тн/



Графикаас "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн нүүрс экспортын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгааг харж болохоор байгаа ба 2018 онд нийт **13.1 сая** тн нүүрс борлуулсан бол 2019 онд **15.5 сая** тн нүүрс борлуулаад байна.



ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



2019 онд нийт 52 худалдан авагчтай байгуулсан 63 борлуулалтын гэрээний хүрээнд 216 тээврийн компанийн 8068 тээврийн хэрэгсэлд 14,568,221 тн нүүрс ачиж тээвэрлэжээ. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад тээврийн компанийн тоо 28.5 хувиар, тээвэрлэсэн нүүрсний хэмжээ 11 хувиар өссөн үзүүлэлт юм.

Тээвэрлэлтийн хариуцлагын гэрээг 170 аж ахуйн нэгжтэй байгуулсан бөгөөд хүчилтын гэрээг нүүрс тээврийн 95 аж ахуйн нэгж, 23 худалдан авагчтай хийж гүйцэтгэлийг хангуулан ажиллажээ.

Энэ оны онцлох бүтээн байгуулалт нь Уурхайгаас Гашуун сүхайтын чиглэлийн авто зам хүртэлх 8.2 км олон улсын стандартад нийцсэн хүнд даацын хатуу хүчилттай авто замын барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн явдал бөгөөд 8 метрийн

зорчих хэсэгтэй, 3.5 метрийн хөвөөтэй нийт 15 метрийн өргөнтэй, 48 см-ийн хүчилтын хийцтэй уг зам ашиглалтад орсноор жолооч нарын аюулгүй, ая тухтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулахад эерэг нөлөө үзүүлж байна.

Нүүрс тээврийн дэд бүтцийг сайжруулах зорилгоор 2019 онд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн санхүүжилтээр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт өрнөж, Тавантолгой-Гашуун сүхайтын төмөр замын ажил эхэлсэн.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад 357 тэрбум төгрөг, Тавантолгой-Гашуунсүхайтын чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад 308.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ



“Эрдэнэс-Тавантолгой” ХК 2019 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны олон улсын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр баталгаажуулалтын сертификатаа гардан авсан. Энэ онд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар журмыг чанд мөрдөн ажиллаж үйлдвэрлэлийн осол, болзошгүй аюулаас бүрэн урьдчилсан сэргийлэн ажилласан.

“Эрдэнэс-Тавантолгой” болон гэрээт компанийн 3967 ажилтнуудыг ХАБЭА-н 4 төрлийн сургалтад хамруулжээ. Шинэ ажилтны сургалтад 2211, жолооны сургалтад 479, мэргэшүүлэх сургалтад 1189, түр ажиллах ажилтны сургалтад 88 ажилтныг тус тус хамруулсан байна.

“Аваар устгах төлөвлөгөө”, “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г танилцуулах сургалтыг 2019 оны 03, 04 дүгээр сард зохион байгуулж 451 ажилтан, “Гал унтраах дадлага сургуулилт”-ыг 2019 оны 09 дүгээр сарын 05-28-ны хооронд зохион байгуулж 4 ээлжийн 454 ажилтныг тус тус хамруулав.



БАЙГАЛЬ ОРЧИН, УСНЫ БОДЛОГО, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Байгаль орчныг хамгаалах, усны зохистой хэрэглээг бий болгох асуудал эн тэргүүний зорилт хэмээн үзэж, энэ чиглэлээр компанийн нийгмийн хариуцлагыг чиглүүлэн ажиллаж байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2019 онд байгаль орчинд учирч болохуйц сөрөг нөлөөлийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх зорилготой менежментийн төлөвлөгөөг БОАЖА-аар батлуулан Цанхийн уурхайн үйл ажиллагаанд хог хаягдал, ус, тоосжилт,

хөрсний элэгдэл, эвдрэл нөхөн сэргээлт зэрэг чиглэлүүдээр төрөлжсөн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллалаа.

2019 онд Байгаль орчны удирдлагын тогтолцооны MNS:ISO 14001 стандартыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Франц Улсын Афнор группээс баталгаажуулалтын гэрчилгээгээ гардан авсан.

КОМПАНИЙН УС АШИГЛАЛТЫН БАЙДАЛ

Уурхайн хэмжээнд нийт гүний усны 21-н худаг байгаагаас 12 худаг ашиглагдаж байна. 2019 онд гүний худгаас нийт **296.3** мянган тонн ус ашигласан байна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн зориулалтаар – **254.1** мянган тонн ус;
- Ахуйн хэрэглээний зориулалтаар – **35.0** мянган тонн ус;

- Мод усалгааны зориулалтаар – **85.7** мянган тонн усыг ашигласан байна.

Цанхийн баруун, зүүн уурхайгаас шавхан зайлуулсан буюу шүүрлийн ус **61.9** мянган тонн, хурын борооны тогтсон ус **168.2** мянган тонн усыг тоосжилт дарах зорилгоор зам усалгаанд ашигласан байна.



Хүснэгт: Компанийн усны хэрэглээ (мянган литр)

Сар	Ахуйн	Үйлдвэрийн	Ойжуулалт	Зам усалгаа	Эх үүсвэр			Бүгд
					Худаг	Шүүрэл	Хурын ус	
I	3494	8829			12323		13698	26021
II	3533	6605		3	10141		12116	22257
III	4355	13663	46	504	18568		17119	35687
IV	3647	8166	229	1020	13063	16038	33940	63040
V	4120	7860	817	1047	13844	26772	34316	74932
VI	3608	13269	1455	583	18915	12160	35899	66974
VII	3172	36156	1563	46	40940	4130	3900	48970
VIII	3102	58555	1560	-	63217		3880	67097
IX	3235	51588	604	-	55427	2585	5072	63084
X	2746	46196	0	971	49913	242	8320	58475
НИЙТ	35015	254091	85719	7245	296350	61927	168260	526537

ТООСОНЦОРЫН АГУУЛАМЖИЙН ХЭМЖИЛТ

Уурхайн үйл ажиллагааны явцад үүсэж буй тоосжилтыг бууруулах зорилгоор 2019 оны 06 дугаар сарын 25-ний өдрөөс гэрээт компаниудад тоосжилт бууруулах 1 сарын аян зарлан ажиллалаа. Тус аяны хүрээнд сул хөрс, түйрмийг тогтмол хусаж цэвэрлэх, усалгааны давтамж нэмэгдүүлэх, технологийн замуудад хайрга болон улаан шороог дэвсэх зэрэг ажлууд

хийж гүйцэтгэсний үр дүнд 5 цэгт хэмжилт хийхэд тоосжилт 10-50 хувиар буурсан үзүүлэлт гарчээ.

Хэмжилтийг уурхай болон хотхоны хэмжээнд нийт 7-н цэгт Dusttrak DRX8533 болон Dusttrak DRX8533 EP багаж ашиглан 7 хоногийн 3 өдөр 24 цагийн тоосны хэмжилт хийж байна.

УРГАМЛЫН МОНИТОРИНГ

2014 оноос Таван толгойн төслийн талбайд ургамлын бүлгэмдлүүдийг илэрхийлж чадах 3 трансектийн дагуу нийт 19 цэг сонгон жилд 2 удаа үзэгдэл зүй болон ургацын хэмжилт хийж байна. Мониторингийн цэгүүдэд 3 удаагийн давталттайгаар 1 м² талбайн ургамлын бүрхэц, зүйлийн бүрэлдэхүүн, арви, өндөр, ургацын жин зэргийг хэмжив.



НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТҮРШИЛТ



Компанийн зүгээс уурхайчдын хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор говийн хөрсөнд бууцай, юуцай, салатны навч, редиск тариалан хураан авч уурхайн ажилчдын хүнсэнд хэрэглэж байгаа бөгөөд гүзээлзгэнэ, ногоон сонгино тариалсан нь амжилттай ургаж байна.

Үйл ажиллагаа эхэлсэн цагаас хойш Цанхи хотхон, Эрдэнэс хотхон болон хотхон дундах цэцэрлэгт хүрээлэн, уурхайн оффисын гадна талбай, зочдын тавцан, мод үржүүлгийн талбай зэрэгт нийт 100972 ширхэг мод тарьсан. 2019 онд 63000 ширхэг мод тарьжээ.

ШОРООН НҮҮРС ТЭЭВРИЙН ЗАМЫН ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Цанхийн уурхайгаас Гашуунсухайт чиглэлийн автозамтай холбогдох 8.2 км хатуу хүчилтэй зам ашиглалтад орсноор хуучин нүүрс тээврийн 10.2 км зам ашиглалтнаас гарч нөхөн сэргээх нөхцөл бий болсон. Компанийн зүгээс замын нөхөн

сэргээлтийн төлөвлөлтийг боловсруулж, хуучин замын тэлэлтэнд өртөхгүй хэсгийн 7 км замыг тэгшилж шимт хөрс дэвсэн техникийн нөхөн сэргээлт хийлээ.

